

ОХУ-ЫН 2007 ОНЫ ТӨРИЙН ДУМЫН СОНГУУЛЬ

2007 оны 12-р дугаар сарын 2-ны ням гаригийн өдөр болсон ОХУ-ын парламентын сонгуульд В.Путины “Нэгдмэл Орос” нам ялалт байгуулав. Саналын хуудсыг бүрэн тоолж дуусахад урьдчилсан дүнгээр 63.2 хувийн санал авч, илт давуу ялалт байгуулах нь тодорхой болжээ. Төрийн Думд суудал эзлэхийн тулд намууд долоон хувийн босго давах ёстой байдаг ажээ. Энэ удаад улс төрийн 11 нам 4.5 мянга гаруй хүнийг нэр дэвшүүлсэн байна. Оросын парламентын энэ удаагийн сонгуулийн нэг онцлог нь гишүүдийг намаар нь сонгосон явдал аж.

Цагийн зөрүүгээр Камчатскийн хязгаар болон Чукотскийн автономит тойрогт хамгийн түрүүнд санал хураалт эхэлжээ. Зөвхөн Москва хотод гэхэд 3278 саналын хэсэг ажилласан байна. Энэ үеэр нийгмийн хэв журмыг сахиулахаар ДЯЯ-ны 300 мянган ажилтан, дотоодын цэргийн 150 мянган цэрэг, сайн дурынхнаас 20 мянган хүн харуул хамгаалалтанд гарчээ. ОХУ-ын ГХЯ-ны албан ёсны төлөөлөгчдийн мэдэгдсэнээр хилийн чанадад нийт 1.7 сая Оросын иргэд саналаа өгсөн бөгөөд 347 санал хураах хэсэг ажилласан байна. Жишээ нь, Их Британид гэхэд Лондон хотод хоёр, Эдинбургт нэг санал өгөх хэсэг ажилласан байна.

Сонгуулийн төв комиссын мэдээлснээр сонгуульд оролцсон 11 намаас дөрөв нь сонгуулийн босгыг давж чадсан байна. Нэгдмэл Орос нам 64.1, Коммунист нам 11.6, Оросын Либерал нам 8.2, Шударга Орос нам 7.8 хувийн санал авснаар парламентад орох эрхтэй болжээ. Харин сонгуульд оролцсон бусад намын хувьд Тариаланчдын нам 2.3, Яблоко 1.6, Барууны хүчний нэгдэл 1, Иргэний хүч 1.1, Оросын эх орончид 0.9, Нийгмийн шударга ёсны нам 0.2, Ардчилсан нам 0.1 хувийн санал тус тус авсан байна. Төрийн Думын сонгуульд оролцсон улс төрийн намууд ойролцоогоор хоёр тэрбум рубль зарлагджээ. Намуудын сонгуулийн сурталчилгаанд гаргасан зардлыг СТК-ын мэдээгээр толилуулахад:

1. “Нэгдмэл Орос” - 370 сая 527542 рубль. Намын сонгуулийн санд орсон нийт хөрөнгө 420 сая 470397 рубль.
2. Либерал ардчилсан нам- 370 сая 199519 рубль. Хандивын санд орсон хөрөнгө 391 сая 573350 рубль.
3. “Шударга Орос” - 375 сая 560840 рубль. Санд орсон хөрөнгө 386 сая 999813 рубль.
4. Коммунист нам- 168 сая 156144 рубль, нийт хөрөнгө 172 сая 48310 рубль.
5. “Барууны хүчнүүдийн холбоо” - 156 сая 109711 рубль, нийт 157 сая 52 мянган рубль.
6. “Оросын эх орончид” - 137 сая 185393 рубль, нийт 138 сая 645000 рубль.

7. Яблоко- 123 сая 597724 рубль, нийт 136 сая 55000 рубль.
8. Ардчилсан нам- 28 сая 581969 рубль, нийт 31 сая 97000 рубль.
9. “Иргэний хүч”- 28 сая 550542 рубль, нийт 29 сая 721280 рубль.
10. Нийгмийн шударга ёсны нам- нийт 20 сая 101562 рублиэс 20 сая 61562 рублийг сонгуульд зарцуулжээ.
11. Газар тариалангийн намын сонгуулийн нийт санд 15 сая 48754 рубль цугласнаас 14 сая 340341 рублийг зарцуулжээ.

Гар утасны томоохон операторууд (Билайн, МТС, Мегафон гэх мэт) Думын сонгуульд оролцохыг уриалсан мессэжний зардалд 600 мянган ам.доллар гаргажээ.

Сонгуулийн төв комиссын төлөөлөгч Владимир Чуровын мэдэгдсэнээр ОХУ-д сонгуульд санал өгөх насны 108 сая иргэн бүртгүүлснээс сонгогчдын ирц 70 хувьтай байсан нь 2003 оны сонгуультай харьцуулахад харьцангуй өндөр ирцтэй байлаа гэжээ. 2003 оны парламентын сонгуульд нийт сонгогчдын 55.75 хувь оролцож байсан бол 2007 оны сонгуульд 7.25 хувиар оролцогчдын тоо өссөн үзүүлэлттэй байна. Энэ удаагийн санал хураалтын нэг онцлог нь парламентын доод танхимыг пропорциональ системээр буюу намын жагсаалтаар бүрдүүлэх явдал байсан юм.

Арав гаруй орон болон олон улсын байгууллагуудын 300 орчим ажиглагч уг сонгуулийн явцыг хянасан байна. Үүний зэрэгцээ сонгуульд оролцсон 11 намаас 1.5 сая ажиглагч тус сонгуулийг хянахаар сонгуулийн хэсэг рүү илгээгдсэн юм.

Гэвч гадаадын ажиглагчид энэхүү сонгуулийн талаар өөрийн санал бодлоо илэрхийлэхдээ оролцогчдын тоо харьцангуй муу байсныг дурьджээ. Мөн уг сонгуульд ажиглагчаар оролцох хүсэлтэй хүмүүс тэр бүр ирж чадаагүй болохыг онцложээ. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөгч Йоран Леннмаркер ОХУ дараа дараачийн сонгуулиар аль болох олон ажиглагчийг урьж байхыг ээвлэжээ. Ингэхдээ зохион байгуулалт, техникийн асуудал сайн байсныг дурдсан байна. Мөн Төрийн Думын сонгуулийн тухай НАТО-гийн ерөнхий нарийн бичгийн дарга Яап де Хооп Схеффер Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан тайлбарт сэтгэл зовниж буйгаа илэрхийлжээ. Тухайлбал, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчиллын болон хүний эрхийн асуудал хариудсан хүрээлэн ажиглагчдаа оролцуулахгүй гэдгээ мэдэгдсэн билээ. Мөн сөрөг хүчин цуглаан зохион байгуулах, өөрийнхөө санаа бодлыг чөлөөтэй илэрхийлэх боломжгүй байсан нь түүнийг бухимдуулсан байна. Германы парламентын төлөөлөгч Рупрехт Поленц ОХУ-ын Төрийн Думын сонгууль ардчилсан бус байсныг онцолсон байна. Тэрбээр хэлэхдээ “Сонгуулийн ирцийг өндөр

байлгаж, “Нэгдсэн Орос”-ыг ялуулахын тулд энэ сарын 2-ны өдөр Кремль хийх ёстой юмаа хийсэн” гэв. Тэрээр ОХУ-ын байдал тогтвортой гэдэгт эргэлзэж байгаага дурдаад иргэний нийгэм нь төрийн байгууллагуудад итгэх үндэслэл байхгүй хэмээн дүгнэжээ.

Харин ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин ялалт байгуулсан намынхандаа баяр хүргэж, Төрийн Думын гишүүдэд хандан өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд хийж бүтээсэн бүхэн нь үр дүнтэй байсныг онцлон тэмдэглээд, талархал илэрхийлжээ. Ерөнхийлөгч В.Путин “Нэгдмэл Орос” намын гишүүнчлэлээс түдгэлзсэн боловч тус намын сонгуулийн кампанит ажилд тэргүүлэх үүрэгтэй оролцож байсан билээ. Тэрээр оросын ард түмнийг “Нэгдмэл Орос” намд итгэл хүлээлгэхийг уриалж байсан юм.

Шударга Орос намын тэргүүн, Холбооны зөвлөлийн дарга С.Миронов ярихдаа: “Нэгдмэл Орос нам ялахад В.Путины дэмжлэг маш их нөлөөлсөн” гэжээ. Ялалт байгуулсан намын тэргүүн, Төрийн Думын доод танхимын дарга Борис Грызлов “Нэгдмэл Орос нам шинэ парламентад ядуурлыг бууруулах, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэхэд голлон анхаарна” гэж мэдэгдлээ.

Оросын либерал ардчилсан намын тэргүүн В.Жириновский сонгуулийн дүнд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн байна. Тэрээр “Хэдэн хувийн саналтай байх нь гол биш, долоон хувийн босгыг давсандаа маш их баяртай байна. Энэ бол зөвхөн урьдчилсан дүн, цаашид энэ дүн 12-13 хувь болж нэмэгдэх нь тодорхой” гэжээ. Харин Оросын коммунист нам сонгуулийн дүнг хүлээн зөвшөөрөхгүй гэж мэдэгдлээ. Тус намын дарга Геннадий Зюганов Засгийн газар сонгуулийг будлиантуулсан гэж үзэж, даруй зогсоохыг уриалсан байна. Түүний нам 11 хувийн санал авч Төрийн Думд орох эрхтэй болоод байгаа ч үүнээс илүү хувьтай гарах байсан гэж үзэж байгаагаа илэрхийлэв. Сонгуулийн өмнө явуулсан санал асуулгаар Сибирь болон зарим мужид Коммунист нам 20 хувийн санал авч байсан учир дээрх сонгуулийн хэсэгт будлиан гарсан нь илэрхий гэж мэдэгджээ.

Санал авсан байдлаас үзвэл Төрийн Думын 450 суудлын 306 нь “Нэгдмэл Орос” намынх болсон байна. Харин Коммунист нам 57, ОЛАН 45, Шударга орос нам 42 суудал авсан гэсэн дүн албан ёсоор гарчээ.

ОХУ-ын Төрийн Думын сонгууль дууссаны дараа Баруунынхан Орос руу шүүмжлэлээ чиглүүлэв. Тухайлбал, Британийн хэвлэл Оросын ард түмнийг албадан сонгуульд оруулсан гэж шүүмжилж байна. Харин энэ асуудалд Оросын Сонгуулийн ерөнхий хороо “Сонгууль хуулийн дагуу ном ёсоор явагдсан” гэж мэдээлж байгаа бол барууны ажиглагчид болон хэвлэл мэдээллийнхэн ил тод, шударга бус хэмээн дүгнэж байна.

ЕАБХАБ-ын Парламентын ассамблейн дэд тэргүүн Кимо Кильонен Оросын парламентыг гүйцэтгэх засаглалыг сонгосон гэж үзэв. Тэрээр “Эхо

Москвы” радиод ярилцлага өгөхдөө “Төрийн хүч нь намтайгаа хутгалдсан” гэж мэдэгдэв. Ерөнхийлөгч ба мужийн захирагчид нэг намаас нэр дэвшсэнийг барууны ажиглагчид дэндүү хууль зөрчсөн хэмээн тооцож байна. Гүйцэтгэх засаглал намуудын улс төртэй холилдох хэрэггүй гэж Кильюнен хэлэхдээ Нэгдмэл Орос нам сонгуулийн өмнөх маргаанаас таггалзснаар сонгогчдод намуудыг жишиж үзэх боломж олгоогүй гэж шүүмжилжээ. Гэхдээ баруунынхан Оросын сонгуулийг ерөнхийдөө ардчилсан гэж дүгнэж болно гэжээ. Учир нь сонгогчдод сөрөг намын төлөө санал өгөх боломж байсан хэмээн үзжээ.

*Мэдээ бэлтгэсэн Ж.Орхон (ОУСХ-ийн
эрдэм шинжилгээний ажилтан)*